



1925

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/363

Улаанбаатар хот

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн
ажилтнуудын улирлын ажлын гүйцэтгэлийг
дүгнэх, үр дүнгийн мөнгөн урамшуулал
олгох журам батлах тухай

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 37 дугаар зүйлийн 37.1.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 61 дүгээр зүйлийн 61.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар “Журам батлах тухай” тогтоол, 395 дугаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 11.9 дүгээр зүйлийн 11.9.2, 15.5 дугаар зүйлийн 15.5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ажилтнуудын улирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэх, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журмыг нэгдүгээр, Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үр дүнгийн мөнгөн урамшуулалтай холбогдон гарах зардлыг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлын ангиллаас гарахыг Санхүү, бүртгэлийн алба (Н.Урансүрэн)-нд зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн алба (Ч.Бямбасүрэн)-нд даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбоотой Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/138 дугаар “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ажилтнуудын улирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэх, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам” тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БЯМБАСҮРЭН



141252310



Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ажилтнуудын улирлын ажлын
гүйцэтгэлийг дүгнэх, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахад энэ журмыг мөрдөнө.

1.2 Энэхүү журмын зорилго нь Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ажилтнуудын хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн гүйцэтгэл, ажилтны төлөвлөгөөний хэрэгжилт зэргийг бодитой үнэлж, түүнд тохирсон урамшууллыг олгох, ажилтнуудын ажлын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлж, идэвхжүүлэх, ажлын үр дүнг, үнэлж, дүгнэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1 Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн журамд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг хангасан нийт ажилтнууд хамаарна.

2.2 Хөлсөөр ажиллах болон бусад гэрээтэй ажилтнуудын ажлын байранд 8 цаг тогтмол ажилладаг байдал, ажлын гүйцэтгэл, тайлан, ажлын цаг ашиглалтыг харгалзан олгох эсэх асуудлыг Ерөнхий захирал шийдвэрлэнэ.

Гурав. Журмыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1 Ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэхдээ дараах зарчмыг удирдлага болгон баримтална. Үүнд:

- 3.1.1 Хууль, дүрэм, журмыг мөрдөх
- 3.1.2 Шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх
- 3.1.3 Ил тод байх
- 3.1.4 Тайлан, мэдээ, мэдээлэл нотлох баримтад тулгуурласан бодитой байх

Дөрөв. Ажлын гүйцэтгэлийг дүгнэж, үр дүнгийн урамшуулал олгохтой холбоотой үйл ажиллагаа, зохицуулалт

4.1 Ажлын гүйцэтгэлийг дүгнэх шат дараалал

- 4.1.1 Ажилтан тухайн сар болон улирлын ажлын төлөвлөгөөний биелэлтээр өөрийгөө үнэлнэ.
- 4.1.2 Ажилтны өөрийн үнэлгээ, ажлын гүйцэтгэлд тулгуурлан харьяалах алба, төв, тасгийн эрхлэгч, дарга нар дүгнэх үйл ажиллагааг дотооддоо нэгжийн хурлаар ил тод зохион байгуулна.
- 4.1.3 Алба, төв, тасгийн эрхлэгч, дарга болон эрхэлсэн захирлуудын ажлын гүйцэтгэлийг Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсэг

үнэлэх ба шаардлагатай тохиолдолд Эмнэлгийн Ерөнхий захирлын саналыг тусгана.

4.1.4 Нийт ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг Хавсралт №-т заасан “Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсэг” нэгтгэн дүгнэнэ.

4.2 Ажлын гүйцэтгэлийг дүгнэх оноо, улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох хувь

4.2.1 Ажлын гүйцэтгэлийг дүгнэх оноо

№	Хамрах албан тушаал, ажлын байр	Өөрийгөө үнэлэх оноо	Тасаг, алба, төвийн дарга, эрхлэгчийн олгох нэмэлт оноо	Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсгийн олгох нэмэлт оноо	Нийт
1	Удирдах ажилтан	90		10	100
2	Тасаг, төв, албаны дарга, эрхлэгч	90		10	100
3	Бусад эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд	80	10	10	100

4.2.1.1 Удирдах ажилтан болон тасаг, төв, албаны дарга, эрхлэгч нар өөрийн ажлын гүйцэтгэлийг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу 90 хүртэл оноогоор үнэлэх ба Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсэг хянан үзэж, нэмэлт онооны шалгуур үзүүлэлтээс хангасан байдлыг харгалзан 10 хүртэл оноог нэмж олгон дүгнэнэ.

4.2.1.2 Бусад эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд өөрийн ажлын гүйцэтгэлийг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу 80 хүртэл оноогоор үнэлэх ба шууд харьяалах тасаг, төв, албаны дарга, эрхлэгч нар нэмэлт онооны шалгуур үзүүлэлтээс хангасан байдлыг харгалзан 10 хүртэл оноо, Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсэг хянан үзэж мөн 10 хүртэл оноог тус тус нэмж олгон дүгнэнэ.

4.2.1.3 Шууд харьяалах тасаг, төв, албаны дарга, эрхлэгч нар ажилтны өөрийн үнэлгээг үнэн зөв, бодит үнэлсэн байдалд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд залруулах үүрэг өгөх ба Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсэгт нэгжийн ажилтнуудын ажлын бодит гүйцэтгэлийг биечлэн танилцуулж, нэмэлт оноо олгох саналыг дэвшүүлэх эрхтэй.

4.2.2 Улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох хувь

4.2.2.1 Улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн үндсэн цалингийн 20 хүртэл хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно.

4.2.2.2 Ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг “Бүрэн хангалттай”, “Хангалттай” гэж үнэлнэ.

4.2.2.3 4.2.2.1, 4.2.2.2-д заасан хувь, хэмжээг дараах хүснэгтийн дагуу нарийвчлан үнэлнэ. Үүнд:

Үнэлгээний хүснэгт - 1

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас тооцох хувь /сард/
90-100	Бүрэн хангалттай	11-20 хувь
71-89	Хангалттай	10 хувь хүртэл
Задаргаа		
Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас тооцох хувь /сард/
100	Бүрэн хангалттай	20
99		19
98		18.1
97		17.2
96		16.3
95		15.4
94		14.5
93		13.6
92		12.7
91		11.8
90		11
89	Хангалттай	10
88		9.5
87		9
86		8.5
85		8
84		7.5
83		7
82		6.5
81		6
80		5.5
79		5
78		4.5
77		4
76		3.5
75		3
74		2.5
73		2
72		1.5
71		1

4.3 Ажлын гүйцэтгэлийг дүгнэх хугацаа

4.3.1 Алба, төв, тасгийн эрхлэгч, дарга ажилтны сарын ажлын гүйцэтгэл, үр дүнг ажилтны өөрийн үнэлгээ, батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дараа сарын

05-ны өдрийн дотор дүгнэж, үнэлгээг ажилтанд танилцуулах ажлыг зохион байгуулна.

4.3.2 Ажилтны тухайн улирлын 3 сарын ажлын үр дүнг нэгтгэн, ажилтнаар гарын үсэг зуруулж, мөн нэгжийн эрхлэгч, дарга гарын үсэг зурж баталгаажуулан улирлын дараагийн сарын 05-ны өдрийн дотор ажил дүгнэх ажлын хэсгийн нарийн бичгийн даргад ирүүлнэ.

4.3.3 Ажилтнуудын тухайн улирлын ажлын гүйцэтгэлийг дараа сарын 15-ны өдрийн дотор дүгнэж, мөнгөн урамшууллыг олгоно.

4.4 Ажлын гүйцэтгэлийг дүгнэх үйл явц

4.4.1 Ажлын үр дүнг дүгнэхдээ ажилтны өвчтэй, захиргааны чөлөөтэй /хувийн/, ээлжийн амралттай, тасалсан зэрэг биеэр ажиллаагүй хугацааны хөдөлмөр оролцооны коэффициентийг тооцон дүгнэнэ. Ажилтан байгууллагын бодлогоор гадаад сургалт, Олон улсын хурал, семинарт хамрагдсан чөлөөний хугацааг хөдөлмөр оролцооны коэффициент бодоход тооцохгүй.

4.4.2 Эмнэлгийн Ерөнхий захирлын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд тушаал гарсан өдрөөс хойш зөрчилгүйд тооцогдох хүртэл хугацаанд ажлын үр дүнгийн урамшууллыг олгохгүй.

4.4.3 Шинээр ажилд орсон ажилтанд ажилласан эхний 3 сарын үр дүнг дүгнэхгүй ба 4 дэх сараас үр дүнг дүгнэнэ.

4.4.4 Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсэг ажилтны ажлын гүйцэтгэлийг батлагдсан шалгуур үзүүлэлтийг дагуу улирал тутам дүгнэнэ.

4.4.5 Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсэг ажилтны ажлын гүйцэтгэлийг дүгнэхдээ алба, төв, тасаг нэгжээс ирүүлсэн үнэлгээг үндэслэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар, тодруулга авснаар оноог хасах болон нэмэгдүүлж болно.

4.5 Албан тушаалтны эзгүйд ажлын гүйцэтгэлийг орлон дүгнэх

4.5.1 Албан тушаалтны эзгүйд орлон ажиллаж буй албан тушаалтан ажилтны өөрийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурлан алба, төв, тасгийн эрхлэгч, даргын саналыг тусган 4.1, 4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллана.

4.5.2 Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсгийн дарга хүндэтгэн үзэх шалтгаанаар эзгүй байгаа тохиолдолд Эмнэлгийн ерөнхий захирлын зөвшөөрсөн ажлын хэсгийн гишүүн орлон ажил дүгнэх ажлыг удирдан зохион байгуулна.

4.6 Ажилтны ажлын гүйцэтгэлийг дүгнэх санал, шийдвэр

4.6.1 Ажлын хэсэг ажилтны ажлын үр дүнг дүгнэхдээ 3.1-д заасан зарчмыг баримтлан хурлаар шийдвэрлэж, саналыг тусгана.

4.6.2 Ажилтны ажлын үр дүнг үнэлж, дүгнэх асуудлыг ажлын хэсэг заавал хурлаар хэлэлцэх бөгөөд гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь оролцсон саналыг хүчинтэйд тооцно.

4.6.3 Ажлын хэсэг ажилтнуудын ажлын үр дүнг дүгнэсэн хурлын шийдвэрийн дагуу ажилтанд олгох улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга 3 хоногийн дотор тооцоолон Ерөнхий захиралд саналыг танилцуулна.

4.6.4 Эмнэлгийн ерөнхий захирал ажилтнуудын ажлын үр дүнг дүгнэсэн саналтай танилцаж, шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийн дарга эсвэл нарийн бичгийн даргаас нэмэлт, тайлбар, тодруулга авч болно.

4.6.5 Ажлын хэсгийн дүгнэлт, саналыг шаардлага хангасан гэж үзвэл Ерөнхий захирал батална.

Тав. Ажилтнуудын улирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлт

5.1 Ажилтны ажлын гүйцэтгэлийг дүгнэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг баримтална. Үүнд:

5.1.1 Удирдах ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн үндсэн шалгуур		Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Оноо	Хувь
А.Нийтлэг шалгуур үзүүлэлт				
Хууль эрх зүйн актын мөрдөлт		Үйл ажиллагаатай холбоотой нийт хууль, дүрэм, журам, тушаалыг мөрдөж, хэрэгжилтийг ханган, ажилтнуудаар мөрдүүлж ажилласан байдал	5	5%
Үйлчилгээний чанар	Үйлчилгээ үзүүлсэн байдал	Эмнэлгийн дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт, үйлчилгээний стандарт мөрдөлт /Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байран дээр мөрдөх нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажиллах/	2.5	10%
		Ажилтан, үйлчлүүлэгч, иргэдэд хүлээгдэл чирэгдэлгүй ажилласан байдал	2.5	
	Ёс зүй, харилцаа, хандлагын байдал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, үйлчлүүлэгч болон нийгэмтэй харилцахдаа ёс зүй, харилцаа хандлагын дутагдал, алдаа, зөрчил гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгч, хамт олноос гомдол гаргаагүй, алдаа, зөрчлийн талаар мэдээлэгдээгүй байх/	5	
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажил эхлэх, дуусах цагийг журамд заасны дагуу цаг бүртгэлийн программд бүртгүүлсэн бүртгэл	5	15%
		Эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт болон гэнэтийн яаралтай хуралд оролцсон байдал		
		Ажлын байран дээр ажлын цагийг оновчтой хуваарилан үр бүтээлтэй ажилласан байдал		
	Ажлын ачаалал	Монгол улсын Засгийн газар, ЭМЯ болон бусад засаг, захиргааны байгууллагуудаас ирүүлсэн шуурхай үүрэг, даалгаврын дагуу сунаж ажиллах, эзгүй ажилтныг орлон ажилласан болон онцгой нөхцөл байдлын үед дайчлагдан ажилласан байдал /Гамшиг, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, тахал/	5	
		Төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан байдал		
		Ажлын баг, хэсэг, комисс, зөвлөлийг удирдсан, томилогдон ажилласан, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан, оролцон ажилласан, төлөвлөгөөт болон		

		удирдлагын өгсөн үүрэг даалгаврын биелэлт		
	Хариуцлага, сахилга бат	Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын зөрчил гаргаагүй байх, ажилтны хүлээх үүргийн биелэлт, хариуцсан өмчийн ашиглалт хамгаалалт	5	
Б. Тусгай шалгуур үзүүлэлт				
Эмнэлгийн үйл ажиллагаа	Ажлын гүйцэтгэл	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын үндсэн чиг үүргийн гүйцэтгэл, чанар /Байгууллагын үйл ажиллагааг хэвийн, тасалдалгүй явуулахад эрхлэх асуудлын хүрээнд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажилласан, засаг, захиргааны байгууллагуудаас ирүүлсэн албан даалгавар, хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмж, албан бичгийн дагуу холбогдох ажлыг зохион байгуулж ажилласан, судалгаа, мэдээ, тайланг цаг хугацаанд нь хүргүүлсэн, ажилтан, үйлчлүүлэгч, иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, дэвшүүлсэн асуудлыг судлан холбогдох арга хэмжээ авсан, шийдвэрлэсэн, эргэн мэдээлсэн байдал, эвлэрүүлэн зуучлал хийсэн болон бусад/	15	60%
		Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, батлагдсан стандарт, удирдамжийн дагуу алдаа зөрчилгүй ажилласан байдал /Албан бичиг, тушаал, дүрэм журам болон бусад бичиг баримтын боловсруулалт, бүртгэл, хадгалалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд шилжүүлэх./	5	
	Удирдлага, манлайлын үйл ажиллагаа	Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэл болон үр дүнгийн гэрээний биелэлт	10	
		Ажлын чиг үүргийн хүрээнд гадаад, дотоод хамтын ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байдал /Гадны байгууллагатай байгуулсан хамтын гэрээ, аж ахуй нэгж, иргэн, ажилтантай байгуулсан гэрээний биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдал, тасаг, төв, албадтай уялдаа холбоотой хамтран ажилласан байдал/	10	
		Хариуцсан албыг зөв, оновчтой удирдан зохион байгуулж, ажилласан байдал /Хариуцсан нэгжийн ажлын гүйцэтгэл, сахилга бат, ёс зүй харилцаа хандлага, хамтын ажиллагаа, оролцоог жигд хангах, ажиллах таатай орчин, нөхцөл, харилцааг бүрдүүлсэн байдал/	5	
	Сургалт, эрдэм шинжилгээ	Сургалтын үйл ажиллагаа болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн идэвх, оролцоо	10	

	Эдийн засаг, төлөвлөлт, менежмент	Байгууллагын бодлогын түвшинд нэн чухал хөгжлийн баримт бичиг, хөтөлбөр, стандарт, удирдамж боловсруулсан, бүтээлч ажил санаачлан хэрэгжүүлсэн, зардал хөрөнгийн хэмнэлт хийсэн, оновчтой төлөвлөлт, зохион байгуулалтыг хийж ажилласан байдал	5	
--	-----------------------------------	--	---	--

5.1.2 Нийт тасаг, төв, дэмжих албадын дарга, эрхлэгч нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн үндсэн шалгуур		Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Оноо	Хувь
А.Нийтлэг шалгуур үзүүлэлт				
Хууль эрх зүйн актын мөрдөлт		Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, тушаал болон удирдамж, арга аргачлал, зааварчилгааны мөрдөлт	5	5%
Үйлчилгээний чанар	Үйлчилгээ үзүүлсэн байдал	Эмнэлгийн дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт, үйлчилгээний стандарт мөрдөлт /Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байран дээр мөрдөх нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажиллах/	2.5	10%
		Үйлчлүүлэгчийг хүлээгдэл чирэгдэлгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байх /Амбулаторийн болон стационарын үзлэг, обход/	2.5	
	Ёс зүй, харилцаа, хандлагын байдал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, үйлчлүүлэгч болон нийгэмтэй харилцахдаа ёс зүй, харилцаа хандлагын дутагдал, алдаа, зөрчил гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгч, хамт олноос гомдол гаргаагүй, алдаа, зөрчлийн талаар мэдээлэгдээгүй байх/	5	
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажил эхлэх, дуусах цагийг журамд заасны дагуу цаг бүртгэлийн программд бүртгүүлсэн бүртгэл	5	15%
		Эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт болон гэнэтийн яаралтай хурал, эмч нарын хурал, конфренцид оролцсон байдал		
	Ажлын ачаалал	Ажлын байран дээр ажлын цагийг оновчтой хуваарилан үр бүтээлтэй ажилласан байдал	5	
		Эмнэлгийн захиргаанаас өгсөн үүрэг, даалгаврын дагуу сунаж ажиллах, эзгүй ажилтныг орлон ажилласан болон онцгой нөхцөл байдлын үед дайчлагдан ажилласан байдал /Гамшиг, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, тахал/	5	

		Давтан үзлэг, яаралтай дуудлага, хүнд өвчтөнтэй ажилласан байдал /энэ нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй тасаг, төвийн дарга, эрхлэгч нарт хамаарна/ Төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан байдал Ажлын баг, хэсэг, комисс, зөвлөлд ажилласан, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд ажилласан, төлөвлөгөөт болон удирдлагын өгсөн үүрэг даалгаврын биелэлт	5	
	Хариуцлага, сахилга бат	Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын зөрчил гаргаагүй байх, ажилтны хүлээх үүргийн биелэлт, хариуцсан өмчийн ашиглалт хамгаалалт		

Б. Тусгай шалгуур үзүүлэлт

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Ажлын гүйцэтгэл	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын үндсэн чиг үүргийн гүйцэтгэл, чанарын удирдлагыг хэрэгжүүлэн ажилласан байдал - Холбогдох стандарт, удирдамж, арга аргачлалын мөрдөлт - Халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрдүүлэн ажилласан, ажиллуулсан байдал - Эмчилгээ, ажил, үйлчилгээтэй холбоотой доголдол, оношийн зөрүү үүсээгүй ажилласан байдал - Эрүүл мэндийн анхан шатны маягт, E health программ, ажлын хяналтын хуудасны хөтлөлт, түүнд тавих хяналт - Судалгаа, мэдээ, тайланг цаг хугацаанд нь хүргүүлсэн байдал - Эмийн болон бусад эд, материалын зохистой хэрэглээ - Үйлчлүүлэгч, иргэд болон ажилтнаас ирүүлсэн санал хүсэлт, дэвшүүлсэн асуудлыг судлан холбогдох арга хэмжээ авсан, шийдвэрлэсэн, эргэн мэдээлсэн, эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал - Цаг үеийн мэдээ, мэдээллийг хариуцсан ажилтнуудад	15	40%
------------------------------	-----------------	---	----	-----

		шуурхай мэдээлж, хүргэн ажилласан байдал - Бусад		
		Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, батлагдсан стандарт, удирдамжийн дагуу алдаа зөрчилгүй ажилласан байдал /Албан бичиг, тушаал, дүрэм журам болон бусад бичиг баримтын боловсруулалт, бүртгэл, хадгалалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд шилжүүлэх./	5	
	Удирдлага, манлайллын үйл ажиллагаа, менежмент	Тасаг, төв, албаны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэл, үр дүнгийн гэрээний биелэлт, эдийн засгийн үр ашигтай ажилласан байдал	10	
		Хариуцсан тасаг, төв, албыг зөв, оновчтой удирдан зохион байгуулж, ажилласан байдал /Хариуцсан нэгжийн ажлын гүйцэтгэл, сахилга бат, ёс зүй харилцаа хандлага, хамтын ажиллагаа, оролцоог жигд хангах, ажиллах таатай орчин, нөхцөл, харилцааг бүрдүүлсэн байдал/	10	
Сургалт		Сургалтын үйл ажиллагаа	10	20%
Эрдэм шинжилгээ, судалгаа		Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн идэвх, оролцоо	10	

5.1.3 Захиргаа болон зарим дэмжих алба, тасгийн менежер, мэргэжилтэн, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн үндсэн шалгуур		Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Оноо	Хувь
А. Нийтлэг шалгуур үзүүлэлт				
Хууль, эрх зүйн актын мөрдөлт		Үйл ажиллагаатай холбоотой нийт хууль, дүрэм, журам, тушаалыг мөрдөж, хэрэгжилтийг ханган, ажилтнуудаар мөрдүүлж ажилласан байдал	5	5%
Үйлчилгээний чанар	Үйлчилгээ үзүүлсэн байдал	Эмнэлгийн дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт, үйлчилгээний стандарт мөрдөлт /Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байран дээр мөрдөх нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажиллах/	2.5	10%
		Ажилтан, үйлчлүүлэгч, иргэдэд хүлээгдэл чирэгдэлгүй ажилласан байдал	2.5	
	Ёс зүй, харилцаа, хандлагын байдал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, үйлчлүүлэгч болон нийгэмтэй харилцахдаа ёс зүй, харилцаа хандлагын дутагдал, алдаа, зөрчил гаргаагүй ажилласан байх	5	

		/Үйлчлүүлэгч, хамт олноос гомдол гаргаагүй, алдаа, зөрчлийн талаар мэдээлэгдээгүй байх/		
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажил эхлэх, дуусах цагийг журамд заасны дагуу цаг бүртгэлийн программд бүртгүүлсэн бүртгэл	5	15%
		Байгууллага болон тасгаас зохион байгуулсан хуралд оролцсон байдал		
		Ажлын байран дээр ажлын цагийг оновчтой хуваарилан үр бүтээлтэй ажилласан байдал		
	Ажлын ачаалал	Төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан байдал	5	
		Ажлын баг, хэсэг, комисс, зөвлөлд ажилласан, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд ажилласан, төлөвлөгөөт болон удирдлагын өгсөн үүрэг даалгаврын биелэлт		
		Монгол улсын Засгийн газар, ЭМЯ болон бусад засаг, захиргааны байгууллагуудаас ирүүлсэн шуурхай үүрэг, даалгаврын дагуу удирдлагын зөвшөөрлөөр сунаж ажиллах, эзгүй ажилтныг орлон ажилласан болон онцгой нөхцөл байдлын үед дайчлагдан ажилласан байдал /Гамшиг, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, тахал/		
Хариуцлага, сахилга бат	Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын зөрчил гаргаагүй байх,ажилтны хүлээх үүргийн биелэлт, хариуцсан өмчийн ашиглалт хамгаалалт	5		
Б. Тусгай шалгуур үзүүлэлт				
Үйл ажиллагаа	Ажлын гүйцэтгэл	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын үндсэн чиг үүргийн гүйцэтгэл /Удирдан манлайлж, идэвх, санаачилгатай ажилласан, албан бичиг болон өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн, судалгаа мэдээ, тайланг үнэн зөв гаргасан, тасаг, төв, албадтай хамтран ажилласан, ажлын байран дээр очиж заавар, зөвлөгөө сургалт, мэдээлэл хийсэн, үзлэг, хяналт, обход хийсэн, ажлын эргэн мэдээлэлт, тайлагналт, тооллого/	15	30%
		Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, батлагдсан стандарт, удирдамжийн дагуу алдаа зөрчилгүй ажилласан байдал /Албан бичиг, тушаал, дүрэм журам болон бусад бичиг баримтын боловсруулалт, бүртгэл, хадгалалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд шилжүүлэх./	5	

	Ажил, үйлчилгээний чанар	Ажилтан болон үйлчлүүлэгчийн тавьсан асуудлыг хүлээгдэл чирэгдэлгүй түргэн шуурхай авч шийдвэрлэсэн, эргэн мэдээлсэн байдал /Ажил, үйлчилгээтэй холбоотой гомдол, санал гараагүй байх/	5	
		Эрхлэх асуудлын хүрээнд ашиглаж буй программ, маягт, ажлын бүртгэлийн хуудас, дэвтрийн бүртгэл, бичиг хэргийн боловсруулалт, хөтлөлт, мэдээллийн сан үүсгэн журмын дагуу архивлан ажилласан байдал	5	
Сургалт, эрдэм шинжилгээ	Сургалт, эрдэм шинжилгээ	Сургалтын үйл ажиллагаа болон эрдэм шинжилгээ, судалгаан дахь идэвх, оролцоо	10	20%
	Бусад	Өөрийгөө хөгжүүлж нэмэлт сургалт, семинарт хамрагдсан, мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байдал	10	

5.1.4 Дотрын эмнэлзүйн анагаах ухааны зөвлөлд харьяалагдах эмч нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн үндсэн шалгуур		Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Оноо	Хувь
А.Нийтлэг шалгуур үзүүлэлт				
Хууль эрх зүйн актын мөрдөлт		Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, тушаал болон удирдамж, арга аргачлал, зааварчилгааны мөрдөлт	5	5%
Үйлчилгээний чанар	Үйлчилгээ үзүүлсэн байдал	Эмнэлгийн дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт, үйлчилгээний стандарт мөрдөлт /Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байран дээр мөрдөх нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажиллах/	2.5	10%
		Үйлчлүүлэгчдэд хүлээгдэл чирэгдэлгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байх /Амбулаторийн болон стационарын үзлэг, обход/	2.5	
	Ёс зүй, харилцаа, хандлагын байдал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, үйлчлүүлэгч болон нийгэмтэй харилцахдаа ёс зүй, харилцаа хандлагын дутагдал, алдаа, зөрчил гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгч, хамт олноос гомдол гаргаагүй, алдаа, зөрчлийн талаар мэдээлэгдээгүй байх/	5	
	Ажлын цаг ашиглалт	Ажил эхлэх, дуусах цагийг журамд заасны дагуу цаг бүртгэлийн программд бүртгүүлсэн бүртгэл	5	15%
		Эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт болон яаралтай хурал, эмч нарын хурал, конференцид оролцсон байдал		

Ажлын ачаалал, хариуцлага		Ажлын байран дээр ажлын цагийг оновчтой хуваарилан үр бүтээлтэй ажилласан байдал		
	Ажлын ачаалал	Давтан үзлэг, яаралтай дуудлага, хүнд өвчтөнтэй ажилласан байдал, эзгүй ажилтныг орлон ажилласан болон онцгой нөхцөл байдлын үед дайчлагдан ажилласан байдал /Гамшиг, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, тахал/ Төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан байдал	5	
	Хариуцлага, сахилга бат	Ажлын баг, хэсэг, комисс, зөвлөлд ажилласан, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд ажилласан, төлөвлөгөөт болон удирдлагын өгсөн үүрэг даалгаврын биелэлт Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын зөрчил гаргаагүй байх, ажилтны хүлээх үүргийн биелэлт, хариуцсан өмчийн ашиглалт хамгаалалт	5	
Б. Тусгай шалгуур үзүүлэлт				
Эмнэлзүйн тусламж, үйлчилгээ	Ажлын гүйцэтгэл	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын үндсэн чиг үүргийн гүйцэтгэл /Амбулатори болон стационарын үзлэг, обход, хүнд өвчтөний шийдвэрлэлт, гардан ажилбарууд, жижүүр, хот доторх дуудлага болон бусад/	10	30%
	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний чанар	Эмчилгээ, үйлчилгээний үл тохирол, тохиолдол гаргаагүй ажилласан /Үйлчлүүлэгчээс тусламж, үйлчилгээтэй холбоотой гомдол гараагүй, оношийн зөрүү үүсээгүй/	5	
		E health программ, өвчний түүх, эрүүл мэндийн анхан шатны маягтын хөтлөлт	5	
		Эмнэлгээс гарсны дараа 30 хоногийн дотор тухайн оношоор хүндрэн эргэн эмнэлэгт хэвтэлт /эмчээс хамаарсан/	5	
	Халдвар, хамгааллын дэглэм мөрдөлт	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын мөрдөлт	5	
Сургалт		Сургалтын үйл ажиллагааны оролцоо	10	20%
Эрдэм шинжилгээ, судалгаа		Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн идэвх, оролцоо	10	

5.1.5. Лаборатори, дүрс, үйл оношийн эмч нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Оноо	Хувь
А.Нийтлэг шалгуур үзүүлэлт			

Хууль эрх зүйн актын мөрдөлт		Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, тушаал болон удирдамж, арга аргачлал, зааварчилгааны мөрдөлт	5	5%
Үйлчилгээний чанар	Үйлчилгээ үзүүлсэн байдал	Эмнэлгийн дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт, үйлчилгээний стандарт мөрдөлт /Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байран дээр мөрдөх нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажиллах/	2.5	10%
		Үйлчлүүлэгчдэд хүлээгдэл чирэгдэлгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байх /Оношилгоо болон шинжилгээ/	2.5	
	Ёс зүй, харилцаа, хандлагын байдал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, үйлчлүүлэгч болон нийгэмтэй харилцахдаа ёс зүй, харилцаа хандлагын дутагдал, алдаа, зөрчил гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгч, хамт олноос гомдол гаргаагүй, алдаа, зөрчлийн талаар мэдээлэгдээгүй байх/	5	
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажил эхлэх, дуусах цагийг журамд заасны дагуу хүний нөөц, хөгжлийн албаны хуруу бүртгэлийн программд бүртгүүлсэн бүртгэл	5	15%
		Эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт болон яаралтай хурал, эмч нарын хурал, конфренцид оролцсон байдал		
		Ажлын байран дээр ажлын цагийг оновчтой хуваарилан үр бүтээлтэй ажилласан байдал		
	Ажлын ачаалал	Яаралтай дуудлага, хүнд өвчтөнтэй ажилласан байдал болон оношилгоо, шинжилгээний өсөлт, эзгүй ажилтныг орлон ажилласан болон онцгой нөхцөл байдлын үед дайчлагдан ажилласан байдал /Гамшиг, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, тахал/	5	
		Төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан байдал		
		Ажлын баг, хэсэг, комисс, зөвлөлд ажилласан, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд ажилласан, төлөвлөгөөт болон удирдлагын өгсөн үүрэг даалгаврын биелэлт		
Хариуцлага, сахилга бат	Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын зөрчил гаргаагүй	5		

		байх,ажилтны хүлээх үүргийн биелэлт, хариуцсан өмчийн ашиглалт хамгаалалт		
Б. Тусгай шалгуур үзүүлэлт				
Эмнэлзүйн тусламж, үйлчилгээ	Ажлын гүйцэтгэл	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын үндсэн чиг үүргийн гүйцэтгэл /Амбулатори болон стационарын үзлэг болон шинжилгээ, обход, хүнд өвчтөний шийдвэрлэлт, гардан ажилбарууд, жижүүр, хот доторх дуудлага болон бусад/	10	30%
	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний чанар	Эмчилгээ, үйлчилгээний үл тохирол, тохиолдол гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгчээс оношилгоо, шинжилгээтэй холбоотой гомдол гараагүй/	5	
		E health программ, өвчний түүх, эрүүл мэндийн анхан шатны маягтын хөтлөлт	5	
		Оношилгоо, шинжилгээний үл тохирол, залруулах, сайжруулах арга хэмжээ /Эмчээс хамаарсан/	5	
	Халдвар, хамгааллын дэглэм мөрдөлт	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын мөрдөлт	5	
Сургалт		Сургалтын үйл ажиллагааны оролцоо	10	20%
Эрдэм шинжилгээ, судалгаа		Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн идэвх, оролцоо	10	

5.1.6. Мэс заслын эмнэлзүйн анагаах ухааны зөвлөлд харьяалагдах эмч нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн үндсэн шалгуур		Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Оноо	Хувь
А.Нийтлэг шалгуур үзүүлэлт				
Хууль эрх зүйн актын мөрдөлт		Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, тушаал болон удирдамж, арга аргачлал, зааварчилгааны мөрдөлт	5	5%
Үйлчилгээний чанар	Үйлчилгээ үзүүлсэн байдал	Эмнэлгийн дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт, үйлчилгээний стандарт мөрдөлт /Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байран дээр мөрдөх нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажиллах/	2.5	10%
		Үйлчлүүлэгчдэд хүлээгдэл чирэгдэлгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байх	2.5	

		/Амбулаторийн болон стационарын үзлэг, обход/		
	Ёс зүй, харилцаа, хандлагын байдал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, үйлчлүүлэгч болон нийгэмтэй харилцахдаа ёс зүй, харилцаа хандлагын дутагдал, алдаа, зөрчил гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгч, хамт олноос гомдол гаргаагүй, алдаа, зөрчлийн талаар мэдээлэгдээгүй байх/	5	
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажил эхлэх, дуусах цагийг журамд заасны дагуу хүний нөөц, хөгжлийн албаны хуруу бүртгэлийн программд бүртгүүлсэн бүртгэл	5	15%
		Эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт болон яаралтай хурал, эмч нарын хурал, конфренцид оролцсон байдал		
		Ажлын байран дээр ажлын цагийг оновчтой хуваарилан үр бүтээлтэй ажилласан байдал		
	Ажлын ачаалал	Давтан үзлэг, яаралтай дуудлага, хүнд өвчтөнтэй ажилласан байдал, эзгүй ажилтныг орлон ажилласан болон онцгой нөхцөл байдлын үед дайчлагдан ажилласан байдал /Гамшиг, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, тахал/	5	
		Төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан байдал		
		Ажлын баг, хэсэг, комисс, зөвлөлд ажилласан, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд ажилласан, төлөвлөгөөт болон удирдлагын өгсөн үүрэг даалгаврын биелэлт		
Хариуцлага, сахилга бат	Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын зөрчил гаргаагүй байх,ажилтны хүлээх үүргийн биелэлт, хариуцсан өмчийн ашиглалт хамгаалалт	5		
Б. Тусгай шалгуур үзүүлэлт				
Эмнэлзүйн тусламж, үйлчилгээ	Ажлын гүйцэтгэл	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын үндсэн чиг үүргийн гүйцэтгэл /Амбулатор болон стационарын үзлэг, обход, хүнд өвчтөний шийдвэрлэлт, мэс заслын цар хүрээ, жижүүр, хот доторх дуудлага болон бусад/	10	30%
	Эмнэлзүйн тусламж,	Эмчилгээ, үйлчилгээний үл тохирол, тохиолдол гаргаагүй ажилласан байх	5	

	үйлчилгээний чанар	/Үйлчлүүлэгчээс тусламж, үйлчилгээтэй холбоотой гомдол гараагүй, оношийн зөрүү үүсээгүй/		
		E health програм, өвчний түүх, эрүүл мэндийн анхан шатны маягтын хөтлөлт	5	
		Давтан хийлгэсэн мэс засал /Эмчээс хамаарсан/	5	
	Халдвар хамгааллын дэглэм мөрдөлт	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын мөрдөлт	5	
Сургалт		Сургалтын үйл ажиллагааны оролцоо	10	20%
Эрдэм шинжилгээ, судалгаа		Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн идэвх, оролцоо	10	

5.1.7. Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, яаралтай тусламжийн эмч нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн үндсэн шалгуур		Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Оноо	Хувь
А.Нийтлэг шалгуур үзүүлэлт				
Хууль эрх зүйн актын мөрдөлт		Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, тушаал болон удирдамж, арга аргачлал, зааварчилгааны мөрдөлт	5	5%
Үйлчилгээний чанар	Үйлчилгээ үзүүлсэн байдал	Эмнэлгийн дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт, үйлчилгээний стандарт мөрдөлт /Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байран дээр мөрдөх нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажиллах/	2.5	10%
		Үйлчлүүлэгчдэд хүлээгдэл чирэгдэлгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байх /Үзлэг, обход/	2.5	
	Ёс зүй, харилцаа, хандлагын байдал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, үйлчлүүлэгч болон нийгэмтэй харилцахдаа ёс зүй, харилцаа хандлагын дутагдал, алдаа, зөрчил гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгч, хамт олноос гомдол гаргаагүй, алдаа, зөрчлийн талаар мэдээлэгдээгүй байх/	5	
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажил эхлэх, дуусах цагийг журамд заасны дагуу хүний нөөц, хөгжлийн албаны хуруу бүртгэлийн программд бүртгүүлсэн бүртгэл	5	15%

		Эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт болон яаралтай хурал, эмч нарын хурал, конференцид оролцсон байдал	5	
		Ажлын байран дээр ажлын цагийг оновчтой хуваарилан үр бүтээлтэй ажилласан байдал		
	Ажлын ачаалал	Давтан үзлэг, яаралтай дуудлага, хүнд өвчтөнтэй ажилласан байдал, эзгүй ажилтныг орлон ажилласан болон онцгой нөхцөл байдлын үед дайчлагдан ажилласан байдал /Гамшиг, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, тахал/		
		Төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан байдал		
	Хариуцлага, сахилга бат	Ажлын баг, хэсэг, комисс, зөвлөлд ажилласан, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд ажилласан, төлөвлөгөөт болон удирдлагын өгсөн үүрэг даалгаврын биелэлт	5	
Б. Тусгай шалгуур үзүүлэлт				
Эмнэлзүйн тусламж, үйлчилгээ	Ажлын гүйцэтгэл	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын үндсэн чиг үүргийн гүйцэтгэл/Үзлэг, обход, хүнд өвчтөний шийдвэрлэлт, гардан ажилбарууд, жижүүр, хот доторх дуудлага болон бусад/	10	30%
	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний чанар	Эмчилгээ, үйлчилгээний үл тохрол, тохиолдол гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгчээс тусламж, үйлчилгээтэй холбоотой гомдол гараагүй/	5	
		Е health программ, өвчний түүх, эрүүл мэндийн анхан шатны маягтын хөтлөлт	5	
		Тусламж, үйлчилгээг цаг алдаж үзүүлэх, алдаа дутагдал, нас баралт /Эмчээс хамаарсан/	5	
	Халдвар хамгааллын дэглэм мөрдөлт	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын мөрдөлт	5	
Сургалт		Сургалтын үйл ажиллагааны оролцоо	10	20%

Эрдэм шинжилгээ, судалгаа	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн идэвх, оролцоо	10	
---------------------------	--	----	--

5.1.8 Сувилахуйн албаны арга зүйчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үр дүнгийн үндсэн шалгуур		Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Оноо	Хувь
А. Нийтлэг шалгуур үзүүлэлт				
Хууль, эрх зүйн актын мөрдөлт		Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, тушаал болон удирдамж, арга аргачлал, зааварчилгааны мөрдөлт	5	5%
Үйлчилгээний чанар	Үйлчилгээ үзүүлсэн байдал	Эмнэлгийн дүрэмт хувцас өмсөлт, энгэрийн тэмдэг зүүлт, үйлчилгээний стандарт мөрдөлт /Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байран дээр мөрдөх нийтлэг хэм хэмжээг мөрдөн ажиллах/	2.5	10%
		Ахлах сувилагч, зохицуулах сувилагч, менежер болон сувилагч, тусгай мэргэжилтэнтэй эелдэг боловсон харилцаж, заавар, зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан байх. Үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангах	2.5	
	Ёс зүй, харилцаа, хандлагын байдал	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, үйлчлүүлэгч болон нийгэмтэй харилцахдаа ёс зүй, харилцаа хандлагын дутагдал, алдаа, зөрчил гаргаагүй ажилласан байх /Үйлчлүүлэгч, хамт олноос гомдол гаргаагүй, алдаа, зөрчлийн талаар мэдээлэгдээгүй байх/	5	
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажил эхлэх, дуусах цагийг журамд заасны дагуу цаг бүртгэлийн программд бүртгүүлсэн бүртгэл	5	15%
		Эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт болон яаралтай хурал, сувилахуйн багийн болон эмнэлзүйн хурал, сувилагч нарын хуралд оролцсон, зохион байгуулсан байдал		
	Ажлын ачаалал	Ажлын байран дээр ажлын цагийг оновчтой хуваарилан, ажлын байрны чиг үүргийн дагуу үр бүтээлтэй ажилласан байдал		
	Ажлын ачаалал	Төлөвлөгөө, тайлан, мэдээ, судалгааг цаг хугацаанд нь гаргасан байдал	5	

		Ажлын баг, хэсэг, комисс, зөвлөлд ажилласан, олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд ажилласан, төлөвлөгөөт болон удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлсэн байдал Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төв, тасаг нэгжийн ахлах сувилагч, ахлах лаборант, ахлах техникч, зохицуулагч сувилагч, сувилагч, тусгай мэргэжилтэн, туслах сувилагчийн ажлын байран дээр очиж заавар, зөвлөгөө өгч, хяналт тавьж, хамтран ажилласан байдал, эзгүй ажилтныг орлон ажилласан болон онцгой нөхцөл байдлын үед дайчлагдан ажилласан байдал /Гамшиг, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, тахал/		
	Хариуцлага сахилга бат	Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын зөрчил гаргаагүй байх, ажилтны хүлээх үүргийн биелэлт, хариуцсан өмчийн ашиглалт хамгаалалт	5	
Б. Тусгай шалгуур үзүүлэлт				
Сувилахуйн тусламж, үйлчилгээ	Ажлын гүйцэтгэл	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын үндсэн чиг үүргийн гүйцэтгэл Сувилахуйн тусламж, үйлчилгээ хариуцсан арга зүйч - Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт үнэлгээ хийж, үр дүнг тооцож сайжруулалт хийсэн байх, сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд эрсдэл, хүндрэл гарахаас сэргийлэх, бууруулах арга хэмжээ зохион байгуулах үйлчилгээний чиглэл, төрөл бүрээр хяналтын хуудас боловсруулж хэрэгжүүлсэн байх Хүний нөөц, сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан арга зүйч – Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хүний нөөцийн хэрэгцээг тогтоох, төлөвлөх, хангах, хуваарилах, зохицуулах замаар гүйцэтгэлд хяналт тавих, сувилагч тусгай мэргэжилтний чадварт суурилсан хөгжлийн шатлалыг	10	30%

		хэрэгжүүлэх, сувилахуйн сургалтыг явуулж, шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, сургалтын үр дүнг тооцох ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах		
		Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, батлагдсан стандарт, удирдамжийн дагуу алдаа зөрчилгүй ажилласан байдал /Албан бичиг, тушаал, дүрэм журам болон бусад бичиг баримтын боловсруулалт, бүртгэл, хадгалалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд шилжүүлэх./	5	
	Сувилахуйн тусламж, үйлчилгээн ий чанар	Сувилахуйн тусламж үйлчилгээг хэвийн, тасалдалгүй, чанартай үзүүлэх чиглэлээр сувилахуйн тусламж үйлчилгээнд стандарт, арга аргачлал, удирдамж заавар, дүрэм, журам тушаалыг хэрэгжилтийг хангах	5	
		E health программ, цахим сувилгааны түүх, эрүүл мэндийн анхан шатны маягтын хөтлөлт,	5	
	Халдвар хамгааллын дэглэм мөрдөлт	Эмнэлзүйн тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын мөрдөлт	5	
Сургалт		Сургалтын үйл ажиллагааны оролцоо Эмнэлгийн хэмжээнд явагдаж байгаа сургалтад оролцсон байдал, бие дааж өөрийгөө хөгжүүлсэн байдал, өөрийн чиг үүргийн хүрээнд сургалтыг зохион байгуулсан, үр дүнг тооцсон байдал	10	20%
Эрдэм шинжилгээ, судалгаа		Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн идэвх, оролцоо, сувилахуйн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хариуцах нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх.	10	

